



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, засаж сэлбэн
орон нутгийн өмчид бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 128,000,000.00 (нэг зуун хорин найман сая) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Сүхбаатар аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Алтансүх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлцэх ажлыг зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан автомашиныг засаж сэлбэн, орон нутгийн өмчит хуулийн этгээдэд (Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын Тамгын газар) эзэмшүүлэх, ашиглуулах, бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Автомашины улсын дугаарыг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201104

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн
26 дугаар тогтоолын хавсралт



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДАНСНААС ХАСАХ,
ЗАСАЖ СЭЛБЭН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ АВТОМАШИН

№	Автомашины марк улсын дугаар	Ашиглал- тад орсон огноо	Арлын дугаар	Балансын нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэг- дэл өртөг
				(төгрөг)		
1	Ландкрузер-200 56-17 УНУ	2014.06.06	JTMHV05J304 139537	128,000,000.00	128,000,000.00	-
НИЙТ ДҮН				128,000,000.00	128,000,000.00	-
				(нэг зуун хорин найман сая)		